

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР №24

Хуралдаан 2013 оны наймдугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 08 минутад эхэлж, 15 цаг 37 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 29 минут үргэлжлэв. Хуралдаан 1 цаг 29 минут үргэлжлэн, 15 цаг 37 минутад хэлэлцэх асуудлаа дуусгав.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">- Хүний эрхийн Үндэсний комиссын Ажлын албаны дарга- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга- Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Александрын Дашдэлэг, Ганхуягийн Агар-Эрдэнэ нарыг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэд нь Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцөд байгааг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадоржид уламжлах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд</p>

		<p>томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Халамханы Бакытжан, Соотонгоогийн Мөнх-Эрдэнэ, Лхагвасүрэнгийн Гүндэгмаа, Лувсанзундуйн Ням, Мөнхжаргалын Өсөхбаяр нарыг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Халамханы Бакытжаныг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтангэрэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Феодорын Ганбаатар, Баасанжавын Оюунцэцэг нарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох төрийн
--	--	--

		<p>жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Феодорын Ганбаатарыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Мэдээллийн технологи шуудан харилцаа холбооны газрын Дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/1235 тоот албан бичиг, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй дахин зарлах тухай</p>	<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнайгийн 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 1/785 тоот албан бичиг, захиалгаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон</p>

		шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.
4	Бусад асуудал: - Олон улсын чуулга уулзалтын бэлтгэл ажлын явцыг танилцуулах	Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга С.Цэдэндамба "Төрийн албаны мерит тогтолцоо: Туршлага сургамж, сорилт, боломж" олон улсын бага хурлын бэлтгэл ажлын явцыг танилцуулав.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ